



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.2, 6.4.3, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Баянчандмань-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусаагүй боловч автозамын ослоос болж эвдэрч гэмтсэн, буруутай этгээд хохирлыг нь барагдуулсан, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нийт 59,267,501.00 (тавин есөн сая хоёр зуун жаран долоон мянга таван зуун нэг) төгрөгийн балансын үнэ, 29,594,238.87 (хорин есөн сая таван зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун гучин найман төгрөг наян долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 1 дүгээр хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Баянчандмань-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 78,837,757.44 (далан найман сая найман зуун гучин долоон мянга долоон зуун тавин долоон төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 77,278,507.44 (далан долоон сая хоёр зуун далан найман мянга таван зуун долоон төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

3. "Баянчандмань-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Одхүүд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Газрыг нөхөн сэргээх, арилжааны зорилгоор ашиглахгүй байх;

3.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001917



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
249 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"Баянчандмань-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж,
сэлбэгээр худалдах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Сэлбэгээр худалдах доод үнэ	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Ниссан Навара маркийн суудлын автомашин 29-13 УНУ улсын дугаартай, арлын дугаар	3/27/2012	ш	1	59,267,501.00	59,267,501.00	29,594,238.87	8,000,000.00	29,673,262.13
	Нийт хөрөнгийн дүн			1 (нэг)		59,267,501.00 (тавин есөн сая хоёр зуун жаран долоон мянга таван зуун нэг)	29,594,238.87 (хорин есөн сая таван зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун гучин найман төгрөг наян долоон мөнгө)	8,000,000.00 (найман сая)	29,673,262.13 (хорин есөн сая зургаан зуун далан гурван мянга хоёр зуун жаран хоёр төгрөг арван гурван мөнгө)

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн
24.9. дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"Баянчандмань-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, сэлбээгээр худалдах хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Сэлбэгээр худалдах доод үнэ	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	АБЗ-ын битумын агуулах	1/1/1979	ш	2	15,738,303.00	31,476,606.00	31,476,606.00		0.00
2	Чулуун нүхэн граж /тев/	10/12/2002	ш	1	8,820,000.00	8,820,000.00	7,260,750.00		1,559,250.00
3	Модон склад /6.х/	10/1/1976	ш	1	2,835,000.00	2,835,000.00	2,835,000.00	50,000.00	0.00
4	Банзан хашаа /раш/	10/1/1980	ш	1	3,800,000.00	3,800,000.00	3,800,000.00	100,000.00	0.00
5	Ёмкост 20 тн	4/1/1987	ш	1	345,500.00	345,500.00	345,500.00	400,000.00	0.00
6	Ёмкост	4/1/1986	ш	1	390,405.00	390,405.00	390,405.00	400,000.00	0.00
7	Ёмкост	1/1/2000	ш	1	1,186,675.00	1,186,675.00	1,186,675.00	500,000.00	0.00
8	Ёмкост 50тн	1/1/2000	ш	1	3,718,975.00	3,718,975.00	3,718,975.00	500,000.00	0.00
9	Ёмкост 50тн	1/1/2000	ш	1	1,421,900.00	1,421,900.00	1,421,900.00	500,000.00	0.00
10	Ёмкост бетоны /10тн/	4/1/1987	ш	1	8,884,200.00	8,884,200.00	8,884,200.00		0.00
11	Түлшний сав /уб/	10/1/1992	ш	1	30,800.00	30,800.00	30,800.00	150,000.00	0.00
12	Асфальто зүсэгч хөрөө	5/1/2010	ш	1	3,200,000.00	3,200,000.00	3,200,000.00	100,000.00	0.00
13	Битумын тогоо	6/30/2000	ш	1	204,500.00	204,500.00	204,500.00	100,000.00	0.00
14	Өндрийн трансформатор	6/1/2001	ш	1	5,788,800.00	5,788,800.00	5,788,800.00	50,000.00	0.00
15	Бетон зуурагч	5/11/2003	ш	1	5,505,700.00	5,505,700.00	5,505,700.00	200,000.00	0.00
16	Түшлэгтэй сандал	12/1/2009	ш	1	165,000.00	165,000.00	165,000.00		0.00
17	Хурлын зөөлөн сандал	12/1/2001	ш	12	88,641.37	1,063,696.44	1,063,696.44		0.00
	Нийт хөрөнгийн дүн			29 (хорин ес)		78,837,757.44 (далан найман сая найман зуун гучин долоон мянга долоон зуун тавин долоон төгрөг дөчин дөрвөн мөнгө)	77,278,507.44 (далан долоон сая хоёр зуун далан нйаман мянга таван зуун долоон төгрөг дөчин дөрвөн мөнгө)	3,050,000.00 (гурван сая тавин мянган)	1,559,250.00 (нэг сая таван зуун тавин есөн мянга хоёр зуун тавин төгрөг)